

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН **ХӨТӨЧ НОМ**



# БАЯН-ӨЛГИЙ

## АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

Казак урианхай ард түмний хүсэлтийг хүлээн авч 1940 оны 8-р сард хуралдсан Улсын VIII их хурлын шийдвэрийн дагуу Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Ховд аймгаас таслан Баян-Өлгий аймгийг бие даасан аймаг болгон байгуулагдсан.

Аймгийн төв: Өлгий хот

Хэдэн сумтай: 13

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 46 704,89 км<sup>2</sup>

Хүн ам: 108,530 хүн (2020 он)

Угсаатан: Казах, Урианхай, Халх, Дөрвөд, Тува болон бусад

Малын тоо толгой: 2,224,680 (2020 он)

Утасны код: +976 (0)142

Шуудангийн дугаар: 83000

ТХ-ийн улсын дугаар: БӨ

Цахим хуудас: <http://www.bayan-olgi.gov.mn/>

Баян Өлгий аймаг нь Монгол улсын нийт казак үндэстэн төвлөрөн суурьшсан онцлогтой аймаг. Хамгийн өндөр цэг нь Алтайн нурууны ноён оргил Хүйтэн (Монгол Улсын хамгийн өндөр цэг) д.т.д 4373 м, хамгийн нам цэг нь Баяннуур сумын төв д.т.д 1301м.

Байгалийн унаган төрхөө хадгалсан нутаг дэвсгэр нь мөнх цаст сүрэг өндөр уулс, удам хөндий хотос, тунгалаг уст гол мөрөн, нуур цөөрөм, рашаан булаг, жимс жимсгэнэ, дэлхийд ховордсон эмийн ургамал, ан амьтан, жигүүртэн шувууд, алт, мөнгө, гянтбогд, төмрийн хүдэр, зэс, хар тугалга зэрэг эрдэс баялагийн арвин их нөөцтэй, уул уурхайн үйлдвэрлэл, эрчимжсэн МАА, улс дамнасан худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс хөгжүүлэх боломжтой аймаг юм.

Үндэс угсаа:

Казах 91%

Урианхай 5,6%

Халх 0,9%

Дөрвөд 0,9%

Тува 0,8%

Бусад 0,6%





Өлгий сум нь 1940 онд байгуулагдсан. 1961 оноос Өлгий хот гэж нэрлэх болсон. 1972 онд АИХ-ын тогтоолоор Өлгий хотын хилийн цэсийг тогтоож газрын хэмжээг 10092 га талбай бүхий газар нутагтай гэж тогтоожээ. Аймгийн нийт хүн амын 1/3 нь буюу 30 хувьтай нь Өлгий хотод төвлөрсөн байна. Монгол Улсын хэмжээнд радио өргөн нэвтрүүлгийн станцын хамгийн өндөр 350 м цамхаг Өлгий хотод байрласан байна.

Өрхийн тоо: 8681

Хүн амын тоо: 38,310

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 1636 км



## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО МОНГОЛЫН БҮРГЭДЧИДИЙН ХОЛБООНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баян-өлгий аймгийн аялал жуулчлалын холбоо нь 2015 онд байгуулагдсан. Холбооны үндсэн зорилго нь: Бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын компаниудын эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн. Холбооны Тэргүүнээр Х.Досжан сонгогдож 11 тэргүүлэх гишүүн 32 үндсэн гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Бүргэдийн баярыг 2000 онд анх З.Казбек, Х.Едилхан, С.Медеухан нар санаачлан зохион байгуулсан ба баярын үеэр бүх бүргэдчдийн анхны хурал болж, Монголын бүргэдчид холбоо нэртэй ТББ-ыг байгуулж, удирдах зөвлөлийн даргаар нь С.Медеухан, гүйцэтгэх захирлаар Х. Едилхан нарыг сонгосон байна. Энэхүү шинэлэг үүсэл санаачлагыг 2001 онд Аймгийн ИТХ- ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн дэмжиж 44 тоот тогтоол гаргаж, бүргэдийн баярыг жил бүр аймгийн иргэдийн уламжлалт баяр болгон зохион байгуулж байхыг Монголын бүргэдчид холбоонд үүрэг болгосон түүхэн шийдвэр гаргасан байдаг. Ийнхүү бүргэдийн баярыг 2000 оноос эхэлэн дээрх шийдвэрийн дагуу жил бүр тасралтгүй зохион байгуулж байна.

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТУУД

## 1-р маршрут:

*/Баруун хойд чиглэл/*

**Чиглэл нь:**

Алтай Таван богд уул-200 км-Цагаан гол-15 км-Хотон, Хурган нуур-200 км-Цагаан салааны хадны сүг зураг-Бага ойгорын бичээс-160 км-Цэнгэл сум-35 км-Улаанхус сум-45 км-Сагсай сум-30 км- Ёлтын уул-185 км

## 2-р маршрут:

*/Урд чиглэл/*

**Чиглэл нь:**

Толбо нуур 45 км-Хөх сэрхий нурууны ДЦГ-110 км-Чихэртэйн рашаан- 60 км- Алтайн их уулс, их гол нуур, КазахАрд түмний амьдрал, ховор ургамалтай танилцах.

## 3-р маршрут:

*/Хойд чиглэл/*

**Чиглэл нь:**

Өлгий хот Ачит нуур-80 км-Ногоон нуурын хүн чулуу, Хадны сүг зурагнууд-80 км-Сийлхэмийн нуруу-300 км-Цагаан нуур-60 км

## 4-р маршрут:

*/Зүүн өмнөд чиглэл/*

**Чиглэл нь:**

Ховд гол-5 км- Баяннуур-120км-Дэвэлийн арал БНГ-90 км-Цамбагарав БЦГ-150 км

# ҮЗМЭРҮҮД

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ЁЛТЫН САВ ГАЗАР

Ёлтын сав газар нь Алтай суманд байрладаг. БНХАУ-тай хиллэдэг бөгөөд Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын үзэсгэлэнт газруудын нэг. Уг газар нь унаган төрөхөө харьцангуй хадгалсан, дэлхийд ховордсон амьтан, ургамлын тархсан нутаг, ойгоор бүрхэгдсэн үзэсгэлэнт байгальтай юм. Энэ бүс нутаг нь байгальд гарч буй хувьсал, байгалийн иж бүрдэлийн өөрчлөлтөд уур амьсгалаас үзүүлэх нөлөө хамгийн чухал байр суурийг эзэлдэг байна. Алтай сумын нутаг дэвсгэр нь дэлхийн бөмбөрцөгийн хойд хагасын дундад өргөрөгт багтдаг учир эх газрын эрс тэс уур амьсгал зонхилно. Ёлтын сав газар нутгийн ихэнх хэсэгт уулархаг ой бүхий газар зонхилдог учраас харьцангуй сэрүүвтэр, чийглэг байдаг. Эрчис мөрөн нь уг Ёлтын сав газраас Ёлт, Сонгинот голуудаас эх аван урсдаг. Дундаж өндөр уулсыг хамаарах бөгөөд Ёлт голын хөндийд 2070 м – ээс ар хажуугаар гацуур – шинэсэн, шинэс – гацууран ойн бүслүүр эхлэж түүний доод хэсгээр эмжээрлэн үетэн – элдэв өвст ойн нугын ургамал зонхилно. Энд эмийн ургамал болон хүнсний ургамлаар баялаг юм. Мөн Ёлтын ам, Бэхтийн гол, Өмхэйт гэдэг газруудад улаалзгана, үхрийн нүд, тошлой, хад зэрэг жимс, жимсгэнэ тархан ургахаас гадна уулын өвөрт сармисан сонгино ургадаг.



# ҮЗМЭРҮҮД

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### АЛТАЙ ТАВАН БОГДЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР

Монгол орны хамгийн баруун зах, хамгийн өндөр цэг бүхий Алтай Таван Богд нь Монгол Алтайн нуруу хэмээх Монголын баруун захаас Говь-Алтай аймгийн нутгийг өнгөртөл 900 гаруй км үргэлжилдэг уулсын "Хоймор" бөлгөө. Хүйтэн, Найрамдал, Малчин, Наран, Бүргэд, Цагаан Суврага бүхий 6 мөнх цаст оргил бүхий хайрханы маань хамгийн өндөр цэг нь улсын хил дээр орших Хүйтэн оргил 4374 м өндөр. Алтай Таванбогдын хамгийн баруун захын мөнх цаст уулууд, уулыг нуга, хээрт Ёлт, Өвчvv уулууд, Хотон, Хоргон нууруудыг оролцуулан 1996 оноос 6362 ам км талбайгаар улсын тусгай хамгаалалтад авч Байгалийн цогцолборт газруудын нэгд бүртгэн авсан. Монголын Аялал жуулчлалын томоохон чиглэлүүдийн нэг бөгөөд олон орны уулчид авиралт хийхээр байнга ирдэг. 7 сараас 9 сар хүртлэх хугацаанд цаг агаар тогтуун, тайван, цэлмэг байх учир замын багцаа, мөсөн голын ангал гэх мэт баримжаалах шаардлагатай саад бэрхшээлүүдийг даван гарахад амар байдаг. Гэхдээ цаг агаарын хувьд хамгийн тогтворгүй газрууын нэг бол Алтай Таван Богд. Нэг өдрийн дотор нар шарж, цас, бороо орж, шуурга тавих нь энгийн үзэгдэл. Өөрөөр хэлбэл нэг өдөр 4 улиралын шинжийг та тэндээс харж болно гэсэн үг. Алтай Таван Богд ууланд Монголын хамгийн том гурван мөсөн гол байдаг. Потанинын мөсөн гол, Александрын мөсөн гол, Гранегийн мөсөн гол.



# ҮЗМЭРҮҮД

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ПОТАНИНЫ МӨСӨН ГОЛ**

Монгол Алтайн нурууны Алтай Таван Богд ууланд Потанин, Александр, Гране гэсэн 10 гаруй том мөсөн голууд байдгаас хамгийн том, хамгийн урт Потаниний мөсөн гол юм. Мөсөн голын урт нь 20 км, өргөн нь 5 км, эзлэх талбай нь 53.5 ам/км гэж гэсэн газарзүйн тодорхойлолт байдаг ч үнэн

хэрэгтээ Потанин мөсөн гол бидний үед урт нь 10.4км, талбай нь 24.3 ам/км болсон байна. Урсах явц нь 4365 метрээс 2873 метрт явагдана. Оросын судлаач эрдэмтэн Потанины нэрээр нэрлэсэн. Мөсөн гол гэдэг нь уулархаг, налуу газарт олон мянган жилийн мөс, цас, хуримтлагдан нягтарснаас болж бий болдог, мөсөн голууд ихэнхдээ мөстлөгийн үед үүссэн байна. Мөсөн гол нь өндөр уулын бүст хүндийн хүч, тал газарт мөсний зузаан буюу өндрөөс хамаарах даралтаас шалтгаалан урсдаг, аварга том мөсний бөөгнөрөл гэж ойлгож болно.

Монгол орны мөстөл, мөсөн голын тухай Оросын эрдэмтэн С.В.Колесников 1963 онд 270 ам км талбайтай 130 мөсөн гол Монгол Алтайд тархсан хэмээн тэмдэглэсэн байхад Н.Т.Кузнецов мөсөн голын талбайг 350 ам км гэжээ. Монголын газарзүйч эрдэмтэн Ж.Цэрэнсодном Орос-Монгол-Хятадын хил дагуу судалгаа хийж, Монгол Алтай нурууны мөсөн голын тоог 240 хүргэж, талбайг 702.7 ам км хэмээн тодорхойлсон байдаг.





# ҮЗМЭРҮҮД

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **БАГА ТҮРГЭНИЙ ХҮРХРЭЭ**

Алтай Таванбогдын байгалийн цогцолборт газрын үзэсгэлэнт газруудын нэг нь Цэнгэл сумын Хотон, Хурган нуурын хөндийн Бага түргэнийн хавцалд орших Бага түргэний хүрхрээ юм. Уг хүрхрээ мөнх цаст уулсаас эх авч урсаж байгалийн үзэсгэлэнт гайхамшигийг цогцлоосон онгон зэрлэг байгаль дунд оршдоогоороо онцлог юм.

Хүрхрээний өндөр нь 15 метр бөгөөд энэ нь тус аймагт оршиж буй хүрхрээнүүдийн хамгийн өндрөөс унан урсаж буй хүрхрээ болж тооцогддог. Эргэн тойрон дахь уулсаараа Сибирь гацуур, шинэс мод, хонин аарц ургадаг бол Бага Түргэний голын хавцал нь бор бургас, бутлаг ургамлаар баялаг. Хавар, зуны сард уулын ширүүн урсгалт голыг өгсөж энэ нутгийн унаган загас болох Монгол хадран сүрэг сүргээрээ дээшилж түрсээ шахдаг. Хүрхрээ орчмын нутаг дэвсгэрийг Алтай Таванбогдын байгалийн цогцолборт газрын аялал жуучлалын бүсэд хамруулсан ба түүнээс дээшхи улсын хил хүртэлх 10000 орчим га талбай газар нутгийг онцгой бүсэд хамруулжээ. Хүрхрээний орчмын Сумдайрых уул, Хөндлөнгийн уул, Дээд ууланд халиун буга, янгир ямаа, цоохор ирвэс, шилүүс мий, нохой зээх зэрэг хөхтөн идээшин нутагладаг бол Алтан гагнуур, Алтайн сонгино зэрэг ховор ургамал элбэг тархаж ургасан байдаг. Мөн Дээд уулын хонхорт мөнх цас, мөсөн голын гаралтай хэд хэдэн цэнгэг устай нуур, цөөрөм бий.



# ҮЗМЭРҮҮД

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **БАГА ОЙГАРЫН ЦАГААН САЛААГИЙН ХАДНЫ СҮГ ЗУРАГ**

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт Алтай таван богдын Бага Ойгар, Усайн Цагаан салаагийн голын савд байдаг. Өргөн нь 500 метр, урт нь 15 километр үргэлжлэх нутагт тархсан хадны сүг зураг бөгөөд шинэ чулуун зэвсгээс хүрэл зэвсгийн үе хамарсан нийт 8000 жилийн түүхийг агуулдаг.

Эрт балар цагийн хүмүүсийн хойч үедээ үлдээсэн зурган захиа бөгөөд нийт 10 мянга гаруй сүг зураг тоологджээ. Өөрөөр хэлбэл, тухайн үеийн уран зургийн галерей юм. Хамарсан талбай хэмжээгээрээ Монголд хамгийн том төдийгүй дэлхийд томоохон дурсгалд тооцогдоно. 1994 онд Монгол, Америк, Оросын эрдэмтэд хамтран судалж судалгааны үр дүнгээ нэгтгэн 1999 онд Парис хотод хэвлүүлснээр дэлхийн археологийн салбарт танигджээ. Зэрлэг үхэр, адуу, буга, янгир, аргаль, чоно, гахай, баавгай, загас, шувуу зэрэг олон төрлийн ан амьтан дүрслэн зурснаас гадна морь унасан хүмүүс, ан гөрөө хийж буй анчид, байлдаж буй цэрэг дайчид, морин тэрэг жолоодсон хүн зэрэг дүрслэл байдаг. Тухайн үеийн ангийн амьтан, гаршуулж буй амьтад, өдөр тутмын ажил үйлээ ийнхүү 8000 жилийн туршид үе улируулан үргэлжлүүлэн зурж үлдээсэн нь үнэхээрийн гайхамшигтай юм. Ийм урт он цагийг туулж нар салхинд бүдгэрсэн ч үндсэн шинж чанараа алдалгүйгээр өнөөг хүрсэн нь ямар их үнэ цэнэтэй дурсгал болохыг гэрчилнэ



# ҮЗМЭРҮҮД

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ТОЛБО НУУР

Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотоос урагш 45 км-т, Өлгийгөөс Ховд хот орох төв замын дагууд Толбо нуур оршино. Энэ нуур нь зүүн өмнөөс баруун хойш сунаж байрлана. Нуурын хотгор тектоник гаралтай, цэнгэг устай, мөстлөгийн гаралтай нуур - хамгийн урт 21,5 км, өргөн 6 км хүр усны мандал нуурын зүүн урд 2089м бол баруун хойд хэсэг Түргэний голын хавьд 2079м байна. Толбо нуур 1000-1500 метрийн харьцах өндөртэй хад асга бүхий нүцгэн уул нуруугаар хүрээлэгдэнэ. Нуурын эргэн тойрны уулсад эртний мөстлөгийн ул мөр тод ажиглагддаг, одоо хир нь Хүнгүй нуруу, Хатуугийн уулс /3820 м/ зэрэг зарим уулын оргилд бага зэрэг үлдэгдэл мөс цас харагдана. Толбо нуурт хэд хэдэн жижиг арал байдгаас хамгийн том нь усны мандлаас дөнгөж цухуйх 4 м өндөр Гичгэний толгой юм. Нуурын ус хуралдуулах сав газрын талбай 1980 хавт.дөр.км юм.

Толбо нуур нь илүүдэл усаа Түргэн голоор Ховд голын баруун гарын цутгал Өмнө голд өгөх боловч хуурай гандуу үед нуурын түвшин доошлоход ширгэж гадагш урсгалгүй болдог байна. Толбо нуурт хүмүүс амарч зугаалах, загасчлахаар ирэх дуртай байдаг. Толбо нуурын эрэгт буудалж тухлах хэд хэдэн сайхан газрууд бий. Толбо нуурын эрэг дагуу шувуудын амьдралыг ажиглах гол газар нь нуурын адагт Түргэний гол гарч буй хэсэг Толбо нуурын Жижиг нуур юм.



# ҮЗМЭРҮҮД

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### АЧИТ НУУР

Алтайн уулархаг нутаг нуур нилээд олонтой боловч Хангайн, Хэнтийн уулсыг бодвол харьцангуй цөөн юм. Ачит нуурын усны ил талбай 311 хавт.дөр.км, хамгийн урт хойноосоо урагш 30 км, өргөн 16 км хүрэх ба 1464 метрийн үнэмлэхүй өндөрт оршино. Ачит нуур 10500 хавт. дөр.км талбайгаас усжиж байгаа нь Ховд голын ус хуралдуулах сав газрын 21 хувьтай тэнцүү байна.

Монгол Алтайн нурууны томоохон салбар Сийлхэм, Түргэний нурууны хур цас, мөсөн голоос эх авч урсах Цагаан нуурын гол, Хатуугийн гол, Бөхмөрөн, Улиастай зэрэг хэд хэдэн гол горхийн усаар тэжээгдэж илүүдэл усаа Усан хоолой нэртэй ганц голоор Ховд голд өгнө. Ачит нуур Дэвэлийн арал орчмоор 158 зүйл шувуу бүртгэгдсэн байдаг. Монгол орны Улаан номонд орсон хар өрөвтас, гангар хун, хээрийн галуу, хошуу галуу, цагаан сүүлт нөмрөг, зэрлэг гургуул, хонин тоодог, жороо тоодог, Азийн цацууль, итэлгэн цахлай зэрэг ховор шувуудтай. Нуур усандаа Алтайн сугас, Монгол хадран зэрэг загастай. Бөхмөрөн голын адагт намагжсан нугатай томоохон садараа адагтай. Өмнөд хэсэг нь хадан хясаа, нуур руугаа түрж ороод эгц хошуу үүсгэсэн байдаг. Зүүн хойд эргээр нь одоогийнхоо түвшнээс 50-60 м өндөр буюу 1520 м үнэмлэхүй өндөрт урьд нуурын усны эзэлж байсан газарт олон жижиг нууртай. Эндээс эртний төрмөлийн амьтны үлдэгдэл олддог. Ачит нуураас баруун хойш орших Шанаган хэмээх газраас түрэгийн бичигт хөшөө үлдсэн .



# БУСАД ҮЗМЭРҮҮД



## ХОТОН ХУРГАН НУУР

Баян-Өлгий аймаг дахь Цэнгэл сумын нутагт байрладаг мөстлөгийн гаралтай цэнгэг уст нуур юм. Хурган нууртай богино /2 км/хоолойгоор холбогдох бөгөөд энэ хоёрнуур нь Ховд голыг тэтгэнэ. Урт 22 км, өргөн 4 км. Нуурын дундаж гүн 26,8 м.Аймгийн төвөөс 90 км зайтай оршдог.

Түүхэнд Хотон нуурын тулаан гэж тэмдэглэгдсэн Ойрад Монголын цөст хөвгүүдийн цөсийг хөөргөж, зүрхийг дэлсүүлсэн тулаан тэртээ 18-р зуунд энэхүү газар болж байсан түүхтэй. Хотон нуурын тулалдаанд Ойрадын зүүнгарын цэргүүд Манжийн 20000 цэргийг бут ниргэж Халх Монголыг манжаас салгахын төлөөх тэмцлийг хийж байсан ажээ.Битүү ой модоор хучигдсан ганц аралтай, цэнгэг уст Хотон нуур нь Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумд далайн түвшинөөс дээш 2084 м-ийн өндөрт оршино. Хотон, Хурган, Даян зэрэг мөстлөгийн гаралтай томоохон нуурууд нь Алтай таван богдын байгалийн цогцолборт газарт оршдог.

## ЦАГААН ГОЛ

Монгол орны дээвэр Алтай Таван Богдын уулсаас эх аван урсах “Цагаан гол”. Баян-Өлгий аймгийн нутагт Алтай таван богд уулнаас эх авсан олон мөсөн голын нэг нь өвөл зунгүй мөстэй хэвээр цав цагаан байдаг тул “Цагаан гол” хэмээн нэрлэсээр иржээ. Нутгийн иргэд энэхүү голын цагаан өнгийг билэгдэж Сүүн гол гэж нэрлэх нь бий.

Цагаан гол нь Таванбогдын зүүн өмнөд хэсгийн мөсөн голоос эх аван урсах Ховд голд цутгадаг бөгөөд тэр цутгал цэгээс доош хагас км газарт зүүн эргийн ус нь сүүн цагаан, баруун эргийнх нь хар өнгөөр ялгарч хоорондоо сүлэлдэхгүйгээр нийлж урсдаг нь сонин гайхамшиг гэлтэй. Өөрөөр хэлбэл, үлгэрт гардаг шулмын нүүр шиг нэг тал нь хар, нэг тал нь цагаан өнгөтэй харагддаг. Цагаан голын нийт урт нь 20км гаруй юм.

## ШИВЭЭТ МАНХАНЫ ХАДНЫ СҮГ ЗУРАГ

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Шивээт хайрхан уулын энгэр бэлийн хад чулуунуудад зурагдсан хадны зураг. Төв Азийн хадны зургийн урлагийн томоохон төвүүдийн нэгд зүй ёсоор тооцогдох олон мянган зураг бүхий Шивээт хайрханы хадны зургийн цогцолбор нь Хар салаа, Цагаан салаа голуудын хөндийд байрладаг.

Алтайн өндөр уулсаар хүрээлэгдсэн, өвс ургамал, ан амьтнаар нэн баялаг уг үзэсгэлэнт хөндий нь "Алтай Таван Богд"-ын байгалийн цогцолборт газрын нэг хэсэг юм. Тус цогцолборын хадны зургуудын ихэнх нь Шивээт хайрхан уулын доод хэсгээр, Хар салаа голын зүүн эргээр тарсан хадны нурангийн хошуурсан хэсгүүдээр байрлана.

# БУСАД ҮЗМЭРҮҮД

## БИТҮҮГИЙН ХҮН ЧУЛУУ

Уйгарын үед холбогдох хүн чулуун хөшөө: Баян-Өлгий аймгийн Сагсай сумын төвөөс баруун тийш 8,5 км-т орших Битүү гэдэг газарт нэгэн том овор хэмжээтэй хүн чулуун хөшөө байх бөгөөд 10×10 м хэмжээтэй талбайд, 120 см өндөр товгор довжооны баруун хэсэгт азимутын 84 хэмийн чиглэлд хандуулан суулгасан байдаг. Хүн чулууг саарал өнгийн боржингоор хийсэн бөгөөд хавтгайдуу оройтой, хоёр чихийг сөхөж өмссөн дугариг малгайг товгор, хонхор зураасаар дүрсэлсэн. Хөмсөг, хамрыг нэгэн үргэлж зураасаар сийлэн, өргөн дугариг царайнд нилээд зайтай зууван хэлбэрийн хоёр нүд, сахалгүй жижгэвтэр амыг хонхор зураасаар дүрсэлсэн. Хоёр чихийг тал цагариг хэлбэрээр товойлгон дүрсэлж доор нь хоёр ээмэг мэт зүйл унжиж байгаагаар гаргасан. Хоёр гараа гэдэсний өмнө авч цүлхэн бөөртэй, дэрэвгэрдүү амсартай ваарыг барихдаа хоёр эрхий хуруу нь цаад талд орсон бололтой хос дөрвөн хуруу нь тодорхой мэдэгдэж байдаг.




## НОГООННУУРЫН ХҮН ЧУЛУУ

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг дахь Уйгурын үед холбогдох хоёр хүн чулуу хөшөө байдаг бөгөөд сумын төвөөс урагш орших Ямаат Улаан орчмоос авч ирсэн гэдэг. Нэг дэх хүн чулууг нь цайвар саарал өнгийн боржингоор босоо хүний дүрс оруулан урласан. Өргөн нүүртэй, урт шувтан эрүүтэй. Хоёр чихэвчийг нь дээш сөхсөн дугариг малгай өмссөн, жирэвгэр хөмсөгтэй, хөмсгийн уулзвараас урт шулуун хамрын зураасыг нэг үргэлж гүвгэрээр дүрсэлжээ. Нүд нь нэлээд том, зууван хэлбэртэй бөгөөд дунд нь аньсага гаргажээ. Сахалгүй, хонхор зураасаар жижигхэн ам дүрсэлсэн байна. Хөмсгийн хоёр үзүүрээс чихэн дээгүүр дугуйран үргэлжилсэн зураас гаргасан нь үсний захыг харуулсан бололтой. Чихийг хоёр үзүүр нь дотогш эргэсэн тал дугуй хэлбэрээр товойлгон дүрсэлж бөөрөнхий унжлага онгин сэнжтэй ээмэг зүүлгэжээ. Цээжинд хувцасны зах заам гаргаагүй бөгөөд хоёр гараа тохойгоор нугалан гэдэсний өмнө шулуун хүзүүтэй тэгш ёроолтой цүндгэр ваарыг хоёр бөөрнөөс нь дөмнөн барьжээ.



## ЦЭНГЭЛ ХАЙРХАН

Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд орших 3943 м-ийн өндөр уул юм. Энэхүү хайрхан нь Монгол Улсын баруун бүс нутагт Алтайн нурууны салбар уулс болох Монгол Алтайн нурууны нэгэн өндөр уул юм. Энэхүү хайрхан нь Таван Богд байгалийн цогцолборт газар болон Хурган нуур, Даян нууруудын зүүнтээ орших бөгөөд эдгээр нуурын ус нь тус хайрханы мөсөн голоос тэжээгддэг. Уулын баруун бэлд дээрх нууруудаас арай жижиг Хар нуур бас бий. Хайрханы зүүн суганаас Хуримт гол ба Хөлцөөтийн голууд эх аван урсдаг. Түүх дурсгал: Эртний хүмүүсийн соёл иргэншлийн нэгэн гайхамшигт бүтээл болох хад, чулуун дээр улаан зосоор зурсан сүг зургууд ба хаданд сийлж зурсан ан амьтан, хүний дүрс бүхий сүг зургуудаас гадны элдэв тамга, тэмдэг, үсэг зурлага Алтайн нуруунд элбэг. Энэ зургууд нь Монгол Алтайд амьдарч байсан хүмүүсийн 2500-3000 жилийн өмнө үйлдэж үлдээсэн түүх соёлын өв сан юм. Алтайн нурууны буган хөшөө Хангайн нурууныхаас нэлээд өвөрмөц ялгаатай бөгөөд бугын оронд адуу зурсан адуун чулуун хөшөө, сэлэмт хөшөө тохиолддог.



# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД

## ТОЛБО НУУРЫН ОРЧМЫН БААЗУУД




### SOUTH RIVER CAMP

📍 Баян-Өлгий аймгийн  
Өлгий сумаас 35км

☎ 99424810  
99422332

🌐 [facebook.com/southernrivercamp/](https://facebook.com/southernrivercamp/)

📄 [lounge.resistors.showroom](https://lounge.resistors.showroom)



### ALTAI'S GOLDEN EAGLE

📍 Баян-Өлгий аймгийн  
Толбо сум Толбо нуурын эрэгт

☎ 99425350  
99488990

🌐 [facebook.com/altai'sgoldeneaglecamp](https://facebook.com/altai'sgoldeneaglecamp)

📄 [lounge.resistors.showroom](https://lounge.resistors.showroom)  
46.2729° N, 102.7790° E



### ALTAI PEAK

📍 Баян-Өлгий аймгийн  
Өлгий сум, 6 баг

☎ 99427003  
95427809

🌐 [facebook.com/altaipeakcamp](https://facebook.com/altaipeakcamp)

📄 [lounge.resistors.showroom](https://lounge.resistors.showroom)  
46.2729° N, 102.7790° E



# ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД

## ӨЛГИЙ ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД



### PAMUKKALE

- 📍 Баян-Өлгий аймгийн Өлгий хот
- ☎ 99199944, 99094593
- 📌 Турк хоол, халал  
[www.facebook.com/pamukkalerestaurant](http://www.facebook.com/pamukkalerestaurant)
- 📍 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### MEDIANA

- 📍 Баян-Өлгий аймгийн Өлгий хот
- ☎ 70100922, 99110842
- 📌 Монгол, Европ хоол  
[www.mediana.mn](http://www.mediana.mn)
- 📍 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### ARVIN

- 📍 Баян-Өлгий аймгийн Өлгий хот
- ☎ 99422700
- 📌 Пицца хүргэлт  
[www.facebook.com/arvinrestaurant](http://www.facebook.com/arvinrestaurant)
- 📍 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## НАУРЫЗЫН БАЯР

Наурыз бол шашны баяр бус, байгаль эхтэйгээ хүйн холбоотой хүн төрөлхтний баяр юм. Наурыз гэдэг нь Перс гаралтай үг бөгөөд нау-шинэ, рыз-өдөр буюу “Шинэ өдөр” гэсэн утгатай ажээ. Өөрөөр хэлбэл өдөр шөнө тэнцэж, шинэ жил гарч байгааг бэлгэддэг. Казакууд нүүдэлчин ард түмэн учраас өвлийн хахир хатуу цагийг өнтэй давж, урин хавартай золгосны баяр болгон тэмдэглэдэг.

### **ХУГАЦАА:**

Жил бүрийн 3-р сарын 21-23

### **ХААНА:**

Аймгийн төв болон бүх сумуудад

### **ХӨТӨЛБӨР:**

- Нээлтийн үйл ажиллагаа
- Үндэсний хувцастай парад жагсаал
- Наурыз көже –бүжгийн баяр
- Казах үндэсний бүх төрлийн тоглоом наадгай шинжилгээний бага хурал
- “Нүүдлийн шувуудын диваажин” аялал хийх



## БҮРГЭДИЙН БАЯР

Бүргэдийн баяр нь бүргэдээр ан хийх уламжлалт соёлын өвийг сэргээн, хойч үеийнхэнд өвлүүлэн уламжлуулах, олон түмэн болон гадаад улсад сурталчлан таниулах, бүргэд сонирхуулах аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий үйлчилгээний нэгж юм.

### **ХУГАЦАА:**

Жил бүрийн 10-р сарын эхээр

### **ХААНА:**

Баян-Өлгий аймгийн Бугат сумын “Саят толгой” хэмээх газар

### **ХӨТӨЛБӨР:**

- Нээлтийн үйл ажиллагаа
- “Тэнгэрийн хаан-бүргэд” шалгаруулах тэмцээн
- Бусад уралдаан тэмцээнүүдийг зохион явуулах
- Баярын хаалтын үйл ажиллагаа



# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## АЛТАЙН УРИАНХАЙН “МӨСӨН СУРЫН ХАРВАА”

Эрт дээр үеэс уламжлан ирсэн өв соёлоо хадгалах, залуу хойч үедээ өвлүүлэх, түүгээр дамжуулан өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд оршино.

### **ХУГАЦАА:**

Жил бүрийн 1-р сарын 2 дахь долоо хоногт

### **ЭВЭНТ БОЛОХ ГАЗАР:**

Баян-Өлгий аймгийн Толбо сумын нутаг, Толбо нуурын мөсөн дээр

### **ХӨТӨЛБӨР:**

- Нийт харваачдын бүртгэл
- Алтайн урианхайн мөсөн сурын нээлт, цуваа харваа
- Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн дунд мөсөн шагайн харвааны тэмцээн
- Мөсөн дээр олс татах тэмцээн
- Өвөл цагийн үндэсний шилдэг хувцас шалгаруулах тэмцээн



## АЛТАЙ ТАВАН БОГД ХАЙРХАНЫГ ТАХИХ ТӨРИЙН ЁСЛОЛ ЭВЭНТ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч 2012 оны 181 дүгээр зарлигаараа Алтай Таванбогд уулыг төрийн тахилгатай уул хайрханы жагсаалтад оруулж, тэнгэрийг тайх ёслолыг таван жилд нэг удаа зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Анх 2014 онд тахиж, 2019 онд хоёр дахь удаагийн Төрийн ахилгат ёслол үйлдэж дараагийн ёслол 2024 онд хийгдэхээр төлөвлөгдөж байна


### **ХУГАЦАА:**

8 дугаар сард

### **ЭВЭНТ БОЛОХ ГАЗАР:**

Алтай Таван Богд уул





# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АЯЛЛЫН МАРШРУТ